



# Ф Ангилал Улсын Аварга Шалгаруулах Тэмцээн 1-р Шат

Зохион байгуулагч:  
Азийн Буудлагын Академи  
Ханан Ар Буудлагын Төв  
Ф Ангилал Буудлага Спортын Холбоо



Asian Shooting Academy



# 1. Ерөнхий мэдээлэл

## Ерөнхий мэдээлэл

Зөвхөн F Class холбоодын гишүүд оролцоно.

Хэзээ: 2026.05.16

Цаг: 10:00 - 17:00

Хаана: Ханан Ар Буудлага Сургалтын Төв

Хураамж: 100,000 төгрөг (Хоцорсон бүртгэл 120,000 төгрөг)

Бүртгэл хаах хугацаа: 2026.05.14 19:00

Бүртгэлийн линк: <https://www.asianshooting.academy/>

## Ангилал

1. **FTR** - Төвийн галтай .223 болон 308 WIN сумаар бууддаг дуран бүхий винтов буу, зэвсгийн жин хөлтэйгөө нийлээд 8.25кг байх.
2. **Опен** - .223 болон 308 WIN-аас бусад сумаар бууддаг дуран бүхий винтов буу, зэвсгийн жин 10кг байх (зэвсэгт хөл бэхэлсэн бол хөлийн жин тооцогдоно).

Дасгалын тоо: 2

Сумны тоо: 30

Бай: 600 ба 800 метр зайнд байрлах онооны бай

Багийн дүн гарах эсэх: Үгүй

## Шагнал

- Эхний 3 байр шалгаруулна.
- Багийн дүн гарахгүй.

1-р байр: Цом, өргөмжлөл

2-р байр: Цом, өргөмжлөл

3-р байр: Цом, өргөмжлөл

# 2. Санамж

## Буу, сум

1. Аливаа сум хэрэгслийг Шүүгч аюултай гэж үзвэл тэмцээнд ашиглахыг зөвшөөрөхгүй.

## Хувцас Хэрэглэл

1. Буудагчид биед эвтэйхэн хувцас, чихэвч, нүдний шилтэй дасгал гүйцэтгэнэ.

## **Аюулгүй Ажиллагааны Шаардлага:**

1. Тэмцээнийг явуулахад аюулгүй ажиллагааны журмыг чанд сахина. Оролцогч тамирчид ба үзэгчдээс аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг биелүүлээгүй тохиолдолд тэмцээний талбайгаас гаргана.
  - Аливаа галт зэвсэгтэй үргэлж цэнэгтэй гэж болгоомжлон харьцана.
  - Галт зэвсэг буудлага үйлдэхээс бусад тохиолдолд үргэлж цэнэггүй байна.
  - Буудлага үйлдэхээс бусад үед гох дээр хуруу тавихгүй.
  - Зэвсгийн хошуу байнга аюулгүй зүгт, буудлагын үед бай руу чиглүүлнэ.
  - Буудлага үйлдэхдээ бай болон эргэн тойрноо байнга хянаж эрсдэлээс сэргийлнэ.
2. Буудлагын талбайд байгаа бүх буудагч нарын буу бууны гэрт магазин угсраагүй, цэнэггүй байдалтай байна.
3. Буудлагын талбайд байгаа хүн бүр хамгаалалтын нүдний шил, чихэвчийг байнга зүүнэ.
4. Шүүгчийн зөвшөөрөлгүйгээр бууг гэрнээс гаргах, магазин угсрахыг хориглоно.
5. Буутай харьцах бүх үйлдэл нь зөвхөн шүүгчийн командаар галын шугам дээр эсвэл “АЮУЛГҮЙН БҮС” дээр хийгдэнэ.
6. “АЮУЛГҮЙН БҮС” гэдэг нь тухайн буудлагын талбайд аюулгүй зүгт хуурай дасгал хийх, бууг задалж угсрах, тослох, засвар үйлчилгээ хийх зэрэг буудахаас бусад үйлдэл хийхийг зөвшөөрсөн газрыг хэлнэ.

## **“Аюулгүйн Бүс”-д Хориглох Зүйл**

1. Сум бүхий магазинд гар хүрэх, сум болон түүнтэй ижил төстэй загварын сум хэрэгслийг гарт барих, буунд сумтай магазин угсрахыг хориглоно.
2. Буудагч галын шугамаас бусад газарт бууг санамсаргүй унагаасан тохиолдолд тэмцээнээс хасагдах арга хэмжээ авагдахгүй ба бууг газраас өөрөө авахыг хориглоно.
3. Талбайн шүүгч унасан бууг газраас авахдаа оролцогч болон үзэгчдийг холдуулж, бууны амыг аюулгүй зүгт харуулан авна.
4. Магазиныг буудлагын талбайн аль ч хэсэгт сумлаж болно.

## **Тэмцээн Явагдах Журам, Оролцогчийг Бүртгэх**

1. Тэмцээнд оролцогч нь зарлагдсан хугацаанд багтан бүртгүүлнэ.
2. Дасгал гүйцэтгэх буудагч нь зөвхөн талбайн шүүгчийн командаар бууг гаргаж цэнэглэнэ.
3. Буудагч өөрийн оноо үнэн зөв бөглөгдсөн эсэхийг нягтлаад гарын үсгээр баталгаажуулна.

## **Тэмцээнээс Дараах Шалтгаанаар Хасна**

1. Дасгал гүйцэтгэх үед зүй бус үг хэллэг хэрэглэсэн буюу спортын бус байдлаар биеэ авч явсан.